

НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БАН ГИ МҮ МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛЫН ДҮНГИЙН ТУХАЙ

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мү гэргийн хамт манай улсад 2009 оны 7 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийлээ.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын айлчлал Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт өөрийн улсын байр сууриа бэхжүүлэх, Монгол, НҮБ-ын харилцаа, хамтын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулан өргөжүүлэхэд онцгой ач холбогдолтой болсон гэж бид дүгнэж байна.

Ерөнхий нарийн бичгийн дарга айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид бараалхаж, Ерөнхий сайд С.Баяртай албан ёсны уулзалт хийв. Түүнчлэн Гадаад харилцааны сайд болон албаны бусад хүнтэй ажил хэргийн уулзалтуудыг амжилттай хийсэн.

Айлчлалын үеэр бид өнгөрсөн 48 жилийн хугацаанд өрнөсөн Монгол, НҮБ-ын хамтын ажиллагаанд үнэлгээ өгч, түүнийг цаашид өргөжүүлэн эрчимжүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

Нэг. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд, Үндэсний хөгжлийн цогц бодлого, “Атрын III аян” үндэсний хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэх; хүнсний хангамжийг сайжруулах; санхүүгийн хямралыг даван туулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх зэрэг чиглэлээр Монгол, НҮБ-ын хамтын ажиллагааг улам эрчимжүүлэхээр тохиролцлоо.

Хоёр. Ерөнхий нарийн бичгийн дарга хөдөө орон нутаг зочилж, малчин айл өрхийн ахуй амьдралтай танилцаж, уур амьсгалын өөрчлөлт Монгол Улсад хэрхэн нөлөөлж байгаа талаар ярилцан, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй” сэдвээр олон нийтэд лекц уншсан нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварыг багасгах, шинэ нөхцөл байдалд дасан зохицоход НҮБ-тай хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх томоохон нэг чиглэл болсон.

Гурав. Ардчилсан тогтолцоо, зах зээлийн эдийн засагт амжилттай шилжсэн, Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулан хэрэгжүүлж буй, үлгэр жишээ цөөхөн орны нэг нь Монгол Улс юм гэж Ерөнхий нарийн бичгийн дарга үнэлсэн. Энэ нь манай улсын төр, засгаас явуулж буй үйл ажиллагааг сайшаасан, түүнийг олон улсын түвшинд таниулах ач холбогдолтой байлаа.

Дөрөв. Ерөнхий нарийн бичгийн даргын айлчлалтай холбогдуулан Монгол Улсаас Чад Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 800 хүний бүрэлдэхүүнтэй батальон илгээх тухай

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гарсан зарчмын шийдвэрийг Ерөнхий нарийн бичгийн дарга талархан хүлээн авч буйгаа илэрхийлсэн. Зэвсэгт хүчний энхийг дэмжих сургалтын төвд зочлох үеэрээ НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд хувь нэмрээ оруулж буй Монгол Улс, түүний дотор хүнд бэршээлтэй тулгарахаас имээлгүй энхийг тогтоох, дайн дажинтай орны нөхцөл байдлыг тогтворжуулах энхийн үйлсэд сахилга баттай, олон улсын түвшинд нэр хүндтэйгээр үүрэг гүйцэтгэж буй Монголын цэрэг дайчдад НҮБ нэн талархалтай байдгаа онцолж, тэдэнд НҮБ-ын зүгээс бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахаа НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга илэрхийлсэн нь Цэргийн байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын оролцоог өргөжүүлэн нэмэгдүүлэх зорилгоо хэрэгжүүлэхэд чухал боллоо.

Тав. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвийн нээлтийн ажиллагаанд биечлэн оролцож далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх талаар НҮБ-аас явуулж буй үйл ажиллагаанд Монгол Улс манлайлах үүрэгтэйгээр оролцож байгааг сайшаасан. Дамжин өнгөрөх тээврийн үр ашигтай тогтолцоог бий болгох, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх болон ядуурлыг бууруулах тухайлбал, дамжин өнгөрөх тээврийн зардлыг бууруулж, хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн тэрхүү төвийн ажиллагааг НҮБ-ын системийн бүх байгууллагын хүрээнд дэмжиж, туслалцаа үзүүлэхээ нотолсон нь далайд гарцгүй, жижиг, эмзэг эдийн засагтай манай улсын Засгийн газрын хүч чармайлтад чухал дэм болно гэж бид үзэж байна.

Зургаа. Ардчилал, сайн засаглалыг бэхжүүлэхэд манай төр, засгаас онцгойлон анхаарч, хэрэгжүүлж буй арга хэмжээг Ерөнхий нарийн бичгийн дарга сайшаасан бөгөөд эл чиглэлээр тухайлбал, жил бүрийн 9 дүгээр сарын 15-нд болдог Олон улсын ардчиллын өдрийг НҮБ-тай хамтран зохион байгуулахаар тохиролцсон.

Долоо. Хүний эрхийн асуудлаарх олон улсын эрх, зүйн хэм хэмжээ, конвенцийн хэрэгжилтийг сайржуулах чиглэлээр НҮБ-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, тухайлбал хүний эрхийн асуудлаарх чадавхийг бэхжүүлэх, тус яамны бүтцийн хүрээнд тусгай нэгжийг байгуулахад НҮБ-аас дэмжлэг үзүүлэхээр болсон.

Айлчлал амжилттай, ажил хэрэгч уулзалтууд үр дүнтэй болсон гэж дүгнэж байна. Энэ нь Монгол, НҮБ-ын хамтын ажиллагаанд томоохон ахиц болно гэж бид үзэж байна.